

Дүүргийн Засаг даргын шагналаар  
шагнах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Хотын иргэн-хотын соёл” хөтөлбөр батлах тухай 26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 380 жилийн ой, Монгол Улсад санхүүгийн алба үүсэн байгуулагдсаны 108 жилийн ойг тохиолдуулан 2019 онд ажил мэргэжлээрээ хамт олноо манлайлж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган идэвх, санаачилгатай ажилласан хавсралтад дурдсан нэр бүхий албан хаагчдыг дүүргийн Засаг даргын шагналаар шагнасугай.

2. Шагналд зарцуулагдах хөрөнгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч /Ж.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ